



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2022.03.14 № 1а / 1169

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ӨМЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ЗАХИРАЛ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол улсын хэмжээнд шинээр батлагдан 2022 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрхзүйн бичиг баримтын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах, нэг худалдан авагчийн тогтолцоог бэхжүүлэх, бусад хэрэгжүүлэх шаардлагатай эрүүл мэндийн бодлогын асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны батлагдсан төсөв нь хязгаарлагдмал учир байгууллагын орлогыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13, 2022 оны 02 дугаар тогтоолын дагуу хүн амын хэрэгцээ, тоо хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээ болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" 2022 оны 49/A/118 дугаар хамтарсан тушаалд үндэслэн тооцоолох,

1.2 Байгууллагын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, стратеги төлөвлөлтийн хүрээнд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг боломжит түвшинд нэмэгдүүлэх, тогтворжуулахад чиглэсэн худалдан авалтын үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах,

1.3 Засгийн Газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаас бусад тохиолдолд хэмнэлтийн горимд шилжиж, тэвчиж болох зардлаас зайлсхийж, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах,

2. Санхүүгийн тайлагнал, зарцуулалтын эрх олгох болон төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд:

2.1 Эрүүл мэндийн яам нь эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн эрхийг нээж буй тул хүсэлтийг урьдчилан төлөвлөж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах байдлаар сар бүрийн 20-ны дотор Эрүүл мэндийн газруудаар дамжуулан илгээж байх,

2.2 Эрүүл мэндийн яам нь харъяа эрүүл мэндийн байгууллагын төсвийн сарын хуваарийн задаргааг байгууллага тус бүрээр нэгтгэх үүрэгтэй. Энэ үүргийг орон нутагт аймгийн эрүүл мэндийн газар хариуцан ажиллах бөгөөд нэгтгэлийг харъяа сумын эрүүл

141422240

мэндийн төв бүрээр төсвийн төлөвлөлтийн “FISCAL” программд оруулан Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газарт ирүүлэх,

2.3 Улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрээс бусад эрүүл мэндийн байгууллага нэмэлт санхүүжилтийн дансгүй байх чиглэлийг Сангийн яамнаас ирүүлсэн 2022 оны 02 дугаар сарын 28-ны 12-1/981 албан тоотой ирүүлсэн. Иймд уг албан тооттой танилцаж, чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах,

2.4 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч буй төсвийн байгууллагууд нэмэлт дансыг 2022 оны 03 дугаар сарын 15-аас хойш ашиглахгүй. Нэмэлт санхүүжилтийн дансанд байгаа үлдэгдлийг үндсэн дансанд шилжүүлж, эх үүсвэрийг тухайн байгууллагын урсгалын зардлын хөтөлбөрийн адилаар, харин зориулалтыг дараах кодын дагуу төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого-120010 гэх ангиллаар төсвийн төлөвлөлтийн “FISCAL” программд шивж оруулна. Үүнд:

- Нэмэлт – Олон улсын байгууллагаас олгосон /83601/
- ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан /83602/
- Нэмэлт – Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг хариу арга хэмжээний санхүүжилтийн хүрээнд:

3.1 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 50/A/119 дугаар тушаалаар “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 67/A/268 болон A/387/99 дүгээр хамтарсан тушаалыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон тул хэрэгжилтийг хангаж ажиллах,

3.2 2022 оны 03 дугаар сарын 01-ээс хойших хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын дагуу харгалзах оношийн хамаарлын бүлгээр “КОВИД-19” халдварын хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг нэхэмжлэх,

3.3 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 23, 2021 оны 04 дүгээр тогтоол шинэчлэгдэж байгаа бөгөөд гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, дархлаажуулалт болон тандалтын ПГУ шинжилгээг дараах байдлаар шийдвэрлэх. Үүнд:

- Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 23 дугаар тогтоолын “Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ”-ний тарифаар (B97)-аар түр нэхэмжлэх;
- Дархлаажуулалт болон тандалтын ПГУ шинжилгээ нь анхан шатны тусламж, үйлчилгээний багцад хамаарах тул 2022 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэнээр тооцсон төсвийг нэмэгдүүлсэн тул Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэхэмжлэхгүй байх;

3.4 ПГУ шинжилгээний санхүүжилтийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/A/118 дугаар “Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны A/117 дугаар тушаалаар зохицуулсан тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын холбогдох багцын дагуу нэхэмжлэх.

4. Бусад хууль эрхзүйн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

4.1. Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ дагуу ажилтны илүү цагийн хөлсийг өөрсдийн санхүүгийн нөөцөд тооцон олгох, ажил үүргийн хуваарь, илүү цагаар ажиллуулах холбогдох зохицуулалтыг байгууллагын дотоод журам, хамтын гэрээнд тусгах,

4.2. Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ны хуралдаанаар эрүүл мэндийн салбарын ажилчдын цалингийн доод хэмжээг тогтоон баталсан. Байгууллагын санхүүгийн нөөц, чадамжид тулгуурлан ажилчдын үндсэн цалинг нэмэгдүүлж буй тохиолдолд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл эсвэл Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Эрүүл мэндийн яаманд саналаа хүргүүлэн, төсвийн хуваарьт тусган батлуулах,

4.3. Хууль эрхзүйн шинэчлэлтэй холбогдуулан байгууллагын төсвийн хуваарийг шинэчлэн 2022 оны 03 сарын 25-ны дотор аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн яаманд ирүүлэх,

4.4. Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг цалингийн бодолтод бүрэн ашиглах,

4.5. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж буй байгууллагууд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар тогтоолыг судлан эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтад анхаарч ажиллах, мэдээлэл технологи, программ хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэх,

4.6. Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, шилэн дансны хөтлөлтийг хугацаанд нь тайлагнах,

Хавсралтаар Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 50/A/119 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/A/118 дугаар “Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны A/117 дугаар тушаал, Сангийн яамнаас ирүүлсэн 2022 оны 02 дугаар сарын 28-ны 12-1/981 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг тус тус хүргүүлж байна.

Хавсралт ... хуудас



С.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022. Ол. 16 № 61/444
танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЭРДЭМБИЛЭГ ТАНАА

Монгол Улсын 2022 оны төсвийн
тухай хуулийг хэрэгжүүлэх тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед эдийн засгийг сэргээж төсвийн орлого нэмэгдүүлэх, төрийн байгууллагын зардлын үр ашгийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төсөв хэмнэх, төсвийн сахилга батыг чангатгаж зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолыг баталсан.

Уг тогтоолд бүх шатны төсвийн захирагч нарыг дөрвөн чиглэлийн хүрээнд хэмнэлт гаргаж ажиллахыг даалгасан ба үүнд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой зарим арга хэмжээний зардлыг 100 хувь хязгаарлах асуудал багтсан болно.

Иймд Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дахь хэсэгт заасан төсвийн хэмнэлтийн чиглэлээс өөрт хамааралтай хэсгийг дагаж мөрдөхөд онцгой анхаарч 2022 оны төсвийн жилд төсвийн хөрөнгөөр автомашин, тавилга эд хогшил, ном хэвлэл худалдан авах, уралдаан тэмцээн, сурталчилгаа болон киноны уран бүтээл хийх, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхэд зориулж худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байхын зэрэгцээ Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх талаар харьяа байгууллагын удирдлагуудад холбогдох чиглэл өгч ажиллахыг хүсье.

Хэрэв Засгийн газрын тогтоолд заасан хязгаарласан асуудлаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан тохиолдолд төсвөөс санхүүжилт олгохгүй болохыг анхаарна уу.

Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг хавсаргав.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ

9766001711



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 388

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11, "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зайлшгүй шаардлагын хүрээнд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын дараахь гишүүдэд даалгасугай:

1.1. коронавирусын халдварын тархалтаас хамгаалах, урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авч, уул уурхайн экспортыг нэмэгдүүлэх, хилийн боомтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх асуудлаар БНХАУ-ын эрх бүхий байгууллага, албан тушаалтантай 2 талын яриа, уулзалт зохион байгуулж, экспортын ачаа тээврийн эргэлтийг эрс сайжруулах, хилийн боомтод халдвар хамгааллын тусгайлсан дэглэм сахиулах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд, 2 талын гадаад харилцааны хүрээнд дипломат шугамаар харилцах шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт;

1.2. чингэлэг тээврийн асуудлаар БНХАУ-ын талаас тавьсан саналыг судалж, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал барьж, ашиглалтад оруулах, гаалийн шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд хилийн боомтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

1.3. орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген, тоног төхөөрөмж бүхий гаалийн төрөлжсөн лабораторийг ашиглаж, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний хэмжээ, чанар, агуулгыг тодорхойлж, хилийн хяналт, шалгалтыг чирэгдэл багатай, шуурхай зохион байгуулж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-г;

1.4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт, холбогдох дэд бүтцийн ажлыг 2022 онд багтаан дуусгахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт.

2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, 2022 онд төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай:

2.1. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 онд төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын хуваарийг хуулийн этгээд бүрээр батлан мөрдүүлж, биелэлтэд оны эхнээс байнгын хяналт тавьж ажиллах;

2.2. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын 2022 оны ажлын үр дүнг үнэлж, дүгнэхдээ тухайн хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэн тэргүүнд харгалзан үзэх;

2.3. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл арга хэмжээг тусгахгүй байх;

2.4. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, мөнгөн хөрөнгийн удирдлагыг дээшлүүлж, үр өгөөжийг өсгөх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг эрс нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

3. Гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хугацаа, зардлыг бууруулахад чиглэсэн дор дурдсан арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т даалгасугай:

3.1. барааг улсын хилээр нэвтрүүлэхэд хийх үзлэг, хяналт шалгалтын давтамж, хугацааг бууруулж, гаалийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан гаалийн бүрдүүлэлтийн хяналтын арга хэлбэрт нэг мөр шилжих, гаалийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь цахимжуулах, эрсдэлийн үнэлгээнд цахим төлбөрийн баримтын систем, мэдээллийг ашиглах;

3.2. татварын хяналт, шалгалт, гаалийн бүрдүүлэлтийн дараахь шалгалтын үйл ажиллагааг иргэн, аж ахуйн нэгжүүдэд давхардуулахгүй байх, нэгдсэн удирдамж, чиглэлээр хангаж, хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх;

3.3. хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан экспорт, импортын гэрчилгээ олгох журмыг шинэчилж, гэрчилгээг цахимаар олгох зохион байгуулалтын арга хэмжээ авч, гадаад худалдаа эрхлэгчээс шаардах бичиг баримтын тоог бууруулах.

4. Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан хот, суурин газар газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг тогтоож, газрын төлбөрийн орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Төсвийн хэмнэлтийн горимд дараахь чиглэлийг баримтлан ажиллаж өр, авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд захирагч нарт тус тус даалгасугай:

5.1. бүх төрлийн сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах;

5.2. сайд нар нэгээс илүүгүй зөвлөх, туслахтай байх, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар дундаа нэг туслахтай, Засгийн газрын агентлагт хуульд өөрөөр заагаагүй бол нэгээс илүүгүй дэд даргатай, дарга нь зөвлөхгүй байх;

5.3. төрийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлдэг төсвийн байгууллагаас тэтгэвэрт гарсан хоёр албан хаагч тутамд орон тооны нэг нөхөн томилгоо хийх;

5.4. бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах.

6. Төсвийн байгууллагын нийтлэг үйлчилгээ (цэвэрлэгээ, харуул хамгаалалт, төвлөрсөн бус халаалт, хоол үйлдвэрлэл, бүх төрлийн засвар, автомашины үйлчилгээ)-г гүйцэтгэж байгаа ажилчдыг сайн дурын үндсэн дээр өөрсдийнх нь санаачилгаар төрийн болон орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар, эсхүл хувийн хэвшлийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг эрх хэмжээнийхээ хүрээнд авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

7. Энэ тогтоолын 6-д заасан нийтлэг үйлчилгээг төрийн болон орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, хувийн хэвшлийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхэд дараахь чиглэл баримтлахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:

7.1. нийтлэг ажил, үйлчилгээг хувийн хэвшил, төрийн болон орон нутгийн өмчит компаниар гүйцэтгүүлэх зорилго нь гагцхүү ажилчдын цалин хөлс, тэтгэмж, урамшуулал зэрэг нийгмийн баталгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх;

7.2. санаачилгыг төсвийн байгууллага болон түүний харьяалах дээд шатны төсвийн захирагч дэмжсэн бол түүнийг нь орон нутгийн засаг захиргаа хэлэлцэж зохих бэлтгэл хангасны үндсэн дээр Сангийн яам төсөвт холбогдох зохицуулалт хийх;

7.3. орон тооны цомхтгол хийхгүй байх, одоо ажиллаж байгаа ажилчдыг үндсэн ажилтнаар шилжүүлэн ажиллуулах, ажилчдын цалин хөлс, урамшуулал, тэтгэвэрт гарахад нь хуульд заасны дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийг одоо байгаа түвшнээс бууруулахгүй олгох талаар холбогдох гэрээнд тусгах;

7.4. холбогдох стандарт, салбар, орон нутгийн онцлогт нийцүүлж үйлчилгээний норм, норматив, тарифыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулах.

8. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төсвийг хүрэх үр дүн, чанар, гүйцэтгэлд нь үндэслэн үр ашигтай, үр дүнтэй хуваарилах тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан дараахь арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

8.1. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд:

8.1.1. бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив тооцох бүрэлдэхүүн, хувьсах зардлаар тооцож санхүүжүүлэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах;

8.1.2. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сар бүр олгож байгаа тэтгэлгийг суралцагчийг сургуулиа төгсөхөд нь нэг удаа олгодог байхаар холбогдох журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах.

8.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад:

8.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуваарилах, санхүүжүүлэх тогтолцоог халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах;

8.2.3. төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, сүлжээг холбогдох байгууллагуудтай хамтран салбар, ажил мэргэжлийн онцлогт нийцүүлэн судлан үзэж, улсын хэмжээнд нэг мөр шинэчлэн тогтоох санал боловсруулж танилцуулах;

8.2.4. хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал, үйлчилгээ үзүүлэх журам, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг баталж мөрдүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд төрийн байгууллага хяналт тавьдаг тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авах.

8.3. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлээр дор дурдсан асуудлаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод:

8.3.1 эрүүл мэндийн тусламж үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд оновчтой, үр дүнтэй санхүүжүүлэх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах;

8.3.2. анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт, хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг хянах болон сахилга бат, хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх;

8.3.3. иргэн цахимаар болон үүрэн холбооны хэрэгсэл ашиглан эрүүл мэндийн байгууллагаас авсан тусламж үйлчилгээний төлбөрөө хянах үйлчилгээг нэвтрүүлэх;

8.3.4. эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний тарифыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлж шинэчлэх;

8.3.5. төсвийн хувьд хагас бие даасан тогтолцоонд шилжин ажиллах төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах ажлыг 2022 онд багтаан дуусгах, тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалтын сахилга бат, хариуцлагыг чангатгах;

8.3.6. эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоо бүрдүүлж, эмчилгээний үр дүнтэй, баталгаатай, хямд аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг бууруулах.

8.4. Орон нутаг дахь соёл, биеийн тамир, спортын байгууллагын төсвийг үйлчилгээний чанар, хүрэх үр дүнгийн гүйцэтгэлд нь үндэслэж хуваарилах аргачлал боловсруулж санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд;

8.5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг салбарын төсөвтэй уялдуулж, үр дүнг үнэлэх тогтолцоо бий болгох чиглэлээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.

9. Орон нутаг дахь нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн ашиглалтын урсгал болон их засварын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгасгай:

9.1. ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв, соёлын төв, театр, чуулга, музей, номын сан, спорт заал, усан бассейн, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын төвийн хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байхаар тооцож халаалт, засвар, үйлчилгээг эдийн засгийн хувьд үр ашигтай байдлаар зохион байгуулах, дулааны хэрэглээг тоолууртай болгох, энэ талаар Засгийн газрын холбогдох гишүүнээс агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргатай жил бүр байгуулах гэрээнд тусгуулах арга хэмжээ авч, гэрээний хэрэгжилтийг дүгнүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд;

8.3.2. анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт, хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг хянах болон сахилга бат, хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх;

8.3.3. иргэн цахимаар болон үүрэн холбооны хэрэгсэл ашиглан эрүүл мэндийн байгууллагаас авсан тусламж үйлчилгээний төлбөрөө хянах үйлчилгээг нэвтрүүлэх;

8.3.4. эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний тарифыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлж шинэчлэх;

8.3.5. төсвийн хувьд хагас бие даасан тогтолцоонд шилжин ажиллах төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах ажлыг 2022 онд багтаан дуусгах, тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалтын сахилга бат, хариуцлагыг чангатгах;

8.3.6. эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоо бүрдүүлж, эмчилгээний үр дүнтэй, баталгаатай, хямд аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг бууруулах.


8.4. Орон нутаг дахь соёл, биеийн тамир, спортын байгууллагын төсвийг үйлчилгээний чанар, хүрэх үр дүнгийн гүйцэтгэлд нь үндэслэж хуваарилах аргачлал боловсруулж санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд;

8.5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг салбарын төсөвтэй уялдуулж, үр дүнг үнэлэх тогтолцоо бий болгох чиглэлээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.

9. Орон нутаг дахь нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн ашиглалтын урсгал болон их засварын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгасугай:

9.1. ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, сумын эрүүл мэндийн төв, соёлын төв, театр, чуулга, музей, номын сан, спорт заал, усан бассейн, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын төвийн хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байхаар тооцож халаалт, засвар, үйлчилгээг эдийн засгийн хувьд үр ашигтай байдлаар зохион байгуулах, дулааны хэрэглээг тоолууртай болгох, энэ талаар Засгийн газрын холбогдох гишүүнээс агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргатай жил бүр байгуулах гэрээнд тусгуулах арга хэмжээ авч, гэрээний хэрэгжилтийг дүгнүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд;

14. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022.02.28 № 12-1/981

танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18-д орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагуудын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээг орон нутгийн чиг үүрэгт хамаарна гэж заасан.

Дээрх хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсрол, сургалтын төв, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг улсын төсвөөс, ТҮ1-ТҮ3 шатлалд хамаарах ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцож холбогдох зохицуулалтыг Монгол Улсын 2022 оны төсөвт тусгасан.

Монгол Улсын 2022 оны төсөв болон Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 22-ны 388 дугаар тогтоолын дагуу нийтлэг ажил, үйлчилгээний санхүүжилт болон зарцуулалтын эрх олгох, тайлагнах тухай чиглэлийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудас.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ

9766002331

2022 оны 02 дугаар сарын өдрийн
12-1/ ..28/..... тоот бичгийн хавсралт



Орон нутаг дахь улсын төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зарцуулалтын эрх олгох, тайлагнах тухай

1. Улсын төсвөөс санхүүжих эх үүсвэртэй орон нутгийн байгууллагын санхүүжилтийг хуваарилах

- Улсын төсвөөс санхүүжих эх үүсвэртэй орон нутгийн байгууллагуудыг санхүүжилтийг нэгдсэн дүнгээр батлагдсан хөтөлбөр зориулалтын дагуу 122005 эдийн засгийн ангиллаар олгоно
- Төсвийн ерөнхийлөн захирагч нь нэгдсэн дансанд олгосон санхүүжилтийг дараагийн ажлын 2 өдөрт багтаан хуваарийн дагуу GFMIStool системээр дамжуулан журнал ваучераар дараах зарлагын ангиллаар хуваарилна

ТЭЗ	Санхүүжилт олгох данс	Хөтөлбөр	Зориулалт, арга хэмжээ	Санхүүжилт очих Эдийн засгийн ангилал	Санхүүжилт хуваарилах Эдийн засгийн ангилал
БШУС	Данс:100900015130-ЕБС-н гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт	71802 - Ерөнхий боловсрол	81801 -үдийн цай хөтөлбөр	122005-Төсвөөс санхүүжих	213105 - Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал
			81806 - Дотуур байрны үйлчилгээ		210502 - Хоол хүнс
			81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт		210801 - Бусад нийтлэг ажил үйлчилгээ төлбөр хураамж
	Данс:100900015131-СӨБ-н гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт	71801 - Сургуулийн өмнөх боловсрол	81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	122005-Төсвөөс санхүүжих	213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг
			81855 - Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт		210502 - Хоол хүнс
	Данс:100900015132-Насан туршийн боловсролын гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт	71806 - Насан туршийн боловсрол	81855 - Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	122005-Төсвөөс санхүүжих	213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг
ЭМС	Данс:100900020091- Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилт	71601 - Нийгмийн эрүүл мэнд	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	122005-Төсвөөс санхүүжих	210801 - Бусад нийтлэг ажил үйлчилгээ төлбөр хураамж
			71602 - Эмнэлгийн тусламж үйлчилгээ		80103 - Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ
		80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг			213207 – Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж
		80821-Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн хураамж			213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг
		81606- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт			210901- Бараа үйлчилгээний бусад зардал
		81612 – Вакцинжуулалт			210501 – Эм бэлд
		81617-Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний	213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг		

			санхүүжилт		
			81707-Агаарын бохирдлыг бууруулах		210501 - Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
Соёлын Сайд	Данс:100900034100 - Орон нутгийн соёлын байгууллагуудын гүйцэтгэлээр олгох санхүүжилт	71702 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 81855- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт 81941-Соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох санхүүжилт	122005 - Төсвөөс санхүүжих	213207- тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг 213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг
ХЗДХС	Данс:100900012002- Хууль зүй, дотоод хэргийн яам	70712 - Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт	80418 -Тусгай эмнэлэгт олгох татаас	122005 -Төсвөөс санхүүжих	212101-Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр
БХСайд	Данс:100900014001- Батлан хамгаалахын яам	70601 - Зэвсэгт хүчний үйл ажиллагаа	80418 -Тусгай эмнэлэгт олгох татаас	122005 -Төсвөөс санхүүжих	212101-Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр
БШУС	Данс:100900015012- Боловсрол, шинжлэх ухааны яам	71803-Дээд боловсрол	80415-Түшиц эмнэлэгт олгох татаас	122005 - Төсвөөс санхүүжих	212101-Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр
БШУС	Данс:100900015012- Боловсрол, шинжлэх ухааны яам	71803-Дээд боловсрол	81856 - Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургуульд олгох татаас	122005 - Төсвөөс санхүүжих	213101- Засгийн газрын дотоод шилжүүлэг

2. Улсын төсвөөс санхүүжих эх үүсвэртэй орон нутгийн байгууллагын зарцуулалтын эрх нээх

- Улсын төсвийн эх үүсвэртэй орон нутгийн байгууллагын төсвийн хуваарийн задаргааг байгууллага тус бүрээр тухайн төсвийн ерөнхийлөн захирагч бэлтгэнэ
- Төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн фискал программын төсвийн төрөл хэсгээс Улс гэсэн сонголттойгоор нэвтэрч төсвийн хуваарийн 12 сарын задаргааг байгууллага бүрээр шивж оруулна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн сарын хуваарийн өөрчлөлт бүхий баазыг ТБТГ-ын ТНХ-тэй холбогдон Фискал программд сар бүрийн ажлын эхний 5 хоногийн дотор нэгтгүүлнэ
- Фискал программд нэгтгэгдсэн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг төрийн сангийн газар ЗГУМС-д нээнэ

3. Нэмэлт санхүүжилт болон зарцуулалтын эрх нээх

- Улсын төсвийн эх үүсвэртэй орон нутгийн байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байх ба нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг урсгал үйл ажиллагааны зардлын хамт тухай ТЕЗ нь Фискал программд шивж оруулна.
- Нэмэлт санхүүжилтийн дараах эх үүсвэрийг тухайн байгууллагын урсгалын зардлын хөтөлбөрийн адилаар харин зориулалтыг дараах кодын дагуу төсөвт байгууллагын

өөрийн үйл ажиллагааны орлого -120010 гэх ангиллаар Фискал програмд шивж оруулна.

- Төсвийн жилийн явцад УИХ-с соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУ-н байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл-Тусгай зориулалт 83601
- ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө-Тусгай зориулалт 83602
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө-Тусгай зориулалт 83603

4. Төсвийн 2022 оны шинэчлэлтэй холбоотойгоор Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг дараах байдлаар бэлтгэн гаргана. Үүнд:

Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагууд нь:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг улсын болон орон нутгийн батлагдсан төсвийн дагуу хоёр тусад нь бэлтгэнэ.
- Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын орон нутгийн төсвөөс санхүүжих зардал нь орон нутгийн төсөвт батлагдана. Батлагдсан төсвийн дагуу орон нутаг дахь улсын төсвийн байгууллагууд нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд бэлтгэн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. И-тайлан програмд орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг дансаар нээсэн буюу хуучин ашиглаж байгаа регистрийн дугаар нууц үгээр нэвтрэн орж мөнгөн гүйлгээний тайлан шивж оруулснаар орон нутгийн төсөвт батлагдсан төсвийн дагуух төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлагнана.
- Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагууд нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг төсвийн тухай хуульд заасан хугацаанд харьяа улсын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. Улсын төсөв болон орон нутгийн эх үүсвэрээс авсан санхүүжилтийг бүгдийг буюу шинэ хуучин данстын бүх мөнгөн гүйлгээг нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ. И-тайлан програмд шинэ дансаар нээсэн эрхээр нэвтрэн орж санхүү байдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, орлого үр дүнгийн тайланг тодруулгуудын хамт шивж оруулна. Харин төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт төсвийн тайланг гаргахгүй.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар:

- Орон нутгийн төсвийн захирагч нар нь орон нутгийн батлагдсан төсвийн дагуу Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг

хуулийн хугацаанд хянан хүлээн авч нэгтгэнэ. Зөвхөн төсвийн гүйцэтгэлийг орон нутгийн төсвийн тайлан, мэдээнд нэгтгэнэ.

- Орон нутаг дахь улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангийн нэгтгэлд шилжүүлнэ. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хаалтын тайланг хийнэ. Хаалтын тайланг хийх зааварчилгааг хавсаргав.

- Орон нутгийн төсвийн захирагч нар нь Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлтийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч орон нутгийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэнэ.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагч нар:

- Улсын төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийн харьяа орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, мэдээг хуульд заасан хугацаанд хянан хүлээн авч нэгтгэнэ.

- Улсын төсөвт батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэл гарах дансыг Фрий баланс програмд “мэдээнд хамаарах” төлөвт оруулсан бөгөөд эдгээр данстын мэдээг сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд нэгтгэн орно.

- Улсын төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн орон нутаг дахь улсын төсөвт байгууллагын хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүйгээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зарцуулах дансыг Фрий баланс програмд “мэдээнд оруулахгүй” төлөвт оруулсан тул нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээнд нэгтгэгдэхгүй. Харин энэ данстын мэдээллийг ашиглан ерөнхийлөн захирагч бүр өөрийн багцын дэлгэрэнгүй төсвийн гүйцэтгэлийн гарган судалгаа шинжилгээ гэх мэт шаардлагатай зүйлд ашиглах боломжтой.

- Орон нутаг дахь улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангийн нэгтгэлд шилжүүлнэ. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд эхлэлтийн балансыг хийнэ. Эхлэлтийн баланс хийх зааварчилгааг хавсаргав.

- Э-Тайлан програмд улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяа орон нутаг дахь улсын төсөвт байгууллагын регистрийн дугаар болон шинээр нээсэн дансаар шинээр байгууллага үүсгэж өгнө.

- Харьяа орон нутаг дахь улсын төсөвт байгууллагуудын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаас эхлэн Э-Тайлан програмд улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нээсэн байгууллагаар санхүүгийн тайланг оруулж тайлагнуулах арга хэмжээг авна.

- Улсын төсөв болон орон нутгийн эх үүсвэрээс авсан санхүүжилтийг бүгдийг буюу шинэ хуучин данстын бүх мөнгөн гүйлгээг нэгтгэсэн тайланг гаргана.
- Төсвийн ерөнхийлөн захирагч нар Санхүүгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгуудыг холбогдох журамд заасны дагуу нэгтгэнэ.
- Өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайланд орон нутгийн өмчийг орон нутгийн өмч хэсэгт тусгайлан тайлагнана.
- Харин орон нутаг дахь улсын төсөвт байгууллагуудаар төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргуулан нэгтгэл хийх шаардлагагүй.
- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон улсын төсвийн ерөнхийлөн захирагч хооронд давхардсан мөнгөн хөрөнгийн устгал хийгдэнэ.

5. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар нь орон нутаг дах улсын төсвийн байгууллагын хуучнаар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хаалтын балансыг дор дурдсан байдлаар хийнэ.

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн шилжүүлэг буюу 213105 дансаар
- Авлага, өглөгийн үлдэгдлийг тодруулга тайланд дансны ангиллын дагуу хорогдсон баганад
- Бараа материалын тайлангийн үлдэгдлийг бараа материалын дансны ангиллын дагуу бүтцийн өөрчлөлтөөр хасагдсан буюу 303 дансаар
- Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг дансны ангиллын дагуу шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр буюу 304 дансаар
- Өмчийн өөрчлөлтийн тайланг дансны ангиллын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд

6. Улсын төсвийн ерөнхийлөн захирагч нар нь орон нутаг дах улсын төсвийн байгууллагын хуучнаар тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын эхлэлтийн балансыг дор дурдсан байдлаар хийнэ.

- Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө буюу 1200047 дансаар
- Өглөг, авлагын үлдэгдлийг тодруулга тайланд дансны ангиллын дагуу нэмэгдсэн баганад
- Бараа материалын тайлангийн үлдэгдлийг бараа материалын дансны ангиллын дагуу хүлээн авахдаа шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр буюу 204 дансаар
- Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг дансны ангиллын дагуу шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр буюу 204 дансаар
- Өмчийн өөрчлөлтийн тайланг дансны ангиллын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд тус тус бүртгэнэ.



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг хоёрдугаар, “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж ажиллах, жагсаалтад тусгагдсан лабораторийн шинжилгээнд гадаад хяналт хийх лавлагаа лабораторийн жагсаалтыг батлуулахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл)-т, эрүүл мэндийн урьдчилан үзлэг шинжилгээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагыг хамруулах тухай журмыг шинэчилж, хэрэгжилтэд хяналт тавьж аргазүйгээр хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Буянтогтох)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Жагсаалт, журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/470, 2016 оны А/228, 2020 оны А/436 дугаар тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.



С.ЭНХБОЛД

141213552

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02
дугаар сарын 08-ны өдрийн 11/1 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь эрүүл мэндийн байгууллага /цаашид эрүүл мэндийн байгууллага гэх/-аас Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тус тус заасан улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгч (иргэн, аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллага)-ийн хүсэлтээр үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү тушаалын зорилго нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод туссан эрүүл мэндийн салбарын нийт зардалд иргэний шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг 25 хувиас хэтрүүлэхгүй байх, иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа шууд төлж буй төлбөрөөс үүдэлтэй санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлэхэд оршино.

1.3. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасан эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамаарч үзүүлэх бөгөөд энэхүү журамд хамаарахгүй.

1.4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

1.5. Төлбөртэй тусламж, үйлчилгээ гэдэгт Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй, үйлчлүүлэгчийн хүсэлтээр эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх энэхүү тушаалын хоёр болон гуравдугаар хавсралтад заасан тусламж, үйлчилгээ хамаарна.

1.6. Бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хангах, туслах үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээ энэ тушаалын гуравдугаар хавсралтад хамаарна.

1.7. Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд тухайн гэрээ байгуулсан тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Тусламж, үйлчилгээний зохицуулалт

2.1. Эрүүл мэндийн байгууллага төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхэд байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй, мөн үйлчлүүлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулах арга хэмжээг авна.

2.2 Лавлагаа лабораторид хийлгэх эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх лабораторийн тусламж, үйлчилгээний гадаад хяналтыг багцын тарифыг энэхүү тушаалын хавсралтаар баталсан шинжилгээ бүрийн төлбөрийн жишиг хэмжээг баримтлан байгууллага хоорондын гэрээгээр зохицуулна.

2.3 Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтын төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын 722-726-д заасан урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөөтэй холбоотой тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн үзүүлнэ.

2.4 Эрүүл мэндийн байгууллага үйлчлүүлэгчийн хүсэлтээр тухайн хэвтэн эмчлүүлж буй өвчний онцлогт тохирсон захиалгат эмчилгээний хоолоор үйлчилж болно.

2.5 Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн нийт батлагдсан орны 15%-иас хэтрэхгүйгээр иргэний хүсэлтийн дагуу тав тух хангасан төлбөртэй өрөөг ажиллуулж болох бөгөөд тасгуудад жигд хуваарилж, үйлчлүүлэгчид сонголтыг бий болгож, зохицуулалтыг хийнэ.

2.6 Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж олсон орлого нь тухайн эрүүл мэндийн байгууллагын жилийн нийт төсвийн 5 хувиас ихгүй байна.

2.7 Гадаадын иргэнд Олон улсын гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал

3.1 Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг төлбөртэй тусламж, үйлчилгээнээс хөнгөлөх нөхцөл болон санхүүгийн дэмжлэг, туслалцаа авах бусад боломжийн талаар ил тод мэдээллээр хангаж, үйлчлүүлэгчийг албан бус төлбөр төлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

3.2 Эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын цахим хуудсанд байрлуулна. Үүнд:

3.2.1 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ;

3.2.2 Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл;

3.2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, оношийн бүлэг тус бүрээр даатгалын сангаас олгож буй санхүүжилтийн хэмжээ, даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ.

3.3 Иргэнээс энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг авахдаа улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэхгүй байгаа шалтгааныг тайлбарлаж, иргэн зөвшөөрсний үндсэн дээр төлбөр авна.

Дөрөв. Хориглох зүйл

4.1 Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо, шинжилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй. Даатгуулагчийн хариуцан төлөх хамтын төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

4.2 Эрүүл мэндийн байгууллагууд энэхүү тушаалын хавсралтуудад заагдсан тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, шинжилгээний хариу өгөх зэрэг нийтлэг үйлчилгээ хамаарна. Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй.

4.3 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

4.5 Эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын хавсралтад заагдсан тусламж, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг өргөтгөх замаар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого нэмэгдүүлэх эх үүсвэр болгохыг хориглоно.

Тав. Бусад

5.1 Үйлчлүүлэгч эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.

5.2 Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалын хоёр болон гуравдугаар хавсралтаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж,

үйлчилгээнээс төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцно.

5.3 Энэхүү тушаалын хоёр болон гуравдугаар хавсралтаар баталсан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлын тушаалаар батлахгүй бөгөөд зайлшгүй шаардлагаар шинэ технологи, хөрөнгө оруулалтаар хийгдсэн тусламж, үйлчилгээ нэмэгдэх бол Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох мэдээллийг албан бичгээр ирүүлж, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.4 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, цалин, хөлс, урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын нөлөөллийг тооцож Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухай бүр шинэчилж мөрдөнө.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 11/12 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт

